










ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот, 2026 оны 6 дугаар сарын 02-ны өдөр

Хуралд оролцон, хурлын тэмдэглэлтэй танилцсан гишүүдийн ирц:

Нэр	
1 Г.Бэхбат (хараат бус гишүүн)	
2 Ц.Баярбаатар (хараат бус гишүүн)	
3 Н.Монсор (хараат бус гишүүн)	
4 Ж.Дэлгэрсайхан (хараат бус гишүүн)	
5 Н.Эрдэнэбат (ердийн гишүүн)	
6 Б.Эрдэнэбилэг (ердийн гишүүн)	
7 Т.Энхмэнд (ердийн гишүүн)	
8 С.Нэргүй (ердийн гишүүн)	
9 Ц.Хангай (ердийн гишүүн)	
Ирцийн дүн	

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 06-р сарын 02-ны өдөр Дугаар 06/01


Улаанбаатар хот

Дарга томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 78 дугаар зүйлийн 78.3, "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.30, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Г.Бэхбатыг томилсугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



Ц.БАЯРБААТАР

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 06-р сарын 02-ны өдөр Дугаар 06/02


Улаанбаатар хот

Нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.53, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргаар М.Баорманга -г томилсугай.

ДАРГА



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ
КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 06-р сарын 02-ны өдөр

Дугаар 06/03

Улаанбаатар хот

Хороодын бүрэлдэхүүнийг томилох тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 81 дүгээр зүйлийн 81.2, 81.4, 81.5, 81.6 дахь хэсэг "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" хувьцаат компани (цаашид "**Компани**" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.46, 7.47, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "**ТУЗ**" гэх)-ийн 2026 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай:
даргаар: Ж.Дэлгэрсайхан (хараат бус гишүүн), гишүүдээр: Н.Монсор (хараат бус гишүүн), Т.Энхмэнд (ердийн гишүүн).

Хоёр. Цалин урамшуулалын хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай:
даргаар: Н.Монсор (хараат бус гишүүн), гишүүдээр: Г.Бэхбат (хараат бус гишүүн), Н.Эрдэнэбат (ердийн гишүүн).

Гурав. Нэр дэвшүүлэх хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай:
даргаар: Ц.Баярбаатар (хараат бус гишүүн), гишүүдээр: Ж.Дэлгэрсайхан (хараат бус гишүүн), Н.Эрдэнэбилэг (ердийн гишүүн).

ДАРГА



Г.БЭХБАТ

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 06-р сарын 02-ны өдөр

Дугаар 06/04

Улаанбаатар хот

Эх үүсвэргүй баталгааны эрх нээлгэх, зээлийн санхүүжилтийн гэрээ хэлэлцээрийг байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.34 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2026 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан НХААГ/20260101317 дугаартай тендер шалгаруулалтад орох зорилгоор 104,368,250.0 (зуун дөрвөн сая гурван зуун жаран найман мянга хоёр зуун тавь) төгрөгийн эх үүсвэргүй баталгааг гаргуулах хүсэлтийн дагуу тус баталгааг доорх нөхцөлтэйгээр гаргахыг зөвшөөрөв.

Эрсдэлийн шимтгэл:

жилийн 4.0%

Баталгааны эрхийн хугацаа :

тендерийн хүчинтэй хугацаанаас хойш 28

хоног дуустал

Хоёр. Эх үүсвэргүй баталгаа ХХБ-ны энгийн нөхцөлтэй зээлд шилжсэн тохиолдолд дараах нөхцлөөр шилжихийг зөвшөөрөв.

Төгрөгийн зээлд шилжсэн тохиолдолд зээлийн хүү:

жилийн 20.4%

Зээлийн хугацаа:

1 сар

Гурав. Энэхүү тогтоолд дурдагдсан зээлийн барьцаанд дараах дансны орлого, борлуулалтын орлогыг 104,368,250.0 дүнгээр барьцаалуулахаар шийдвэрлэв.

Дөрөв. Энэхүү зээлийг сунгахтай холбогдуулан ХХБ-тай байгуулах зээлийн гэрээ, зээлийн эрх нээх гэрээ, эх үүсвэргүй аккредитив баталгааны эрх нээх гэрээ, барьцааны гэрээ болон холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Ц.Хангайд олгов.

ДАРГА

Г.БЭХБАТ


ГИШҮҮД

Ц.БАЯРБААТАР

Б.ЭРДЭНЭБИЛЭГ


Н.МОНСОР

Т.ЭНХМЭНД







Ж.ДЭЛГЭРСАЙХАН



Н.ЭРДЭНЭБАТ



С.НЭРГҮЙ



Ц.ХАНГАЙ

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ХУВЬЦААТ КОМПАНИ

2026.05.29

Улаанбаатар хот

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал

ТУЗ-ийн 2025.06.02 -ны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлууд:

- (i) ТУЗ-ийн даргаар хараат бус гишүүнийг томилон баталгаажуулах,
- (ii) Нарийн бичгийн даргийг томилон баталгаажуулах,
- (iii) ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, Аудит, Цалин урамшуулалын хороодын гишүүдийг томилох.
- (iv) Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан Сэлбэ дэд бүтэцийн хувиарлах байгууламж (РП) барих тендер шалгаруулалтад шаардлагатай эх үүсвэргүй 104,368,250.0 (зуун дөрвөн сая гурван зуун жаран найман мянга хоёр зуун тавь) төгрөгийн баталгаа гаргах